ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.03.15 № 02/50 УАГ-ГАГ/2017/02 - СА

ХУЛД СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ц.ТУЯАЦЭЦЭГ ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Үндэсний аудитын газрын харьяа Дундговь аймгийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-д гүйцэтгэлийн аудит хийх явцад 72,420,123 /Далан хоёр сая дөрвөн зуун хорин мянга нэг зуун хорин гурав/ төгрөгийн барилгын их засварын ажлыг хувийн хэрэгт тусгаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Барилын тухай хуулийн 33.1.18. -д /Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмыг батлах;/, 46.1.2. /энэ хуулийн 33.1.18-д заасан журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх;/, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалаар батлагдсан барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмын 1.3-д /Барилга байгууламжийн хувийн хэрэг нь тухайн барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд хийгдсэн өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэл, их засварын ажил, үзлэг шалгалт, гарсан эвдрэл, гэмтэл, согогийн талаарх мэдээлэл, уг барилга байгууламжийн үндсэн үзүүлэлтийг агуулсан баримт бичиг байна./ гэж заасны тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /*Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих*/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /*Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх*/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /*Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*:/ гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Барилгад хувийн хэрэг нээж их засварын ажлыг тусган баяжуулалт хийх.

1000000712

57

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэхийг Хулд сумын цэцэрлэгийн эрхлэгч /Ц.Туяацэцэг/, нягтлан бодогч /Э.Хонгорзул/ нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН[1]:** **ЗӨВШӨӨРСӨН:**

Ахлах шинжээч Ч.Бэрхсайхан

Эрхлэгч Ц.Туяацэцэг

Нягтлан бодогч Э.Хонгорзул

---

[1] *Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтны үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*